



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 6/19

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Тамгын газрын даргын 2012 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 73 дугаар тушаалаар батлагдсан "Улсын Дээд шүүхийн Ахмадын зөвлөлийн гишүүдийн талаар авах арга хэмжээний тухай журам"-ын 10.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Дээд шүүхийн гишүүн асан Д.Минжүүр нь өвчний улмаас нас барсан тул Улсын Дээд шүүхээс түүний ар гэрийнхэнд 500.000 /таван зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Холбогдох хуульд заасны дагуу Д.Минжүүрийн ар гэрийнхэнд олгох 500.000 төгрөгт ногдох хувь хүний албан татвар чөлөөлөгдөх болохыг дурдсугай.
3. Буцалтгүй тусламжийн 500.000 төгрөгийг төсвийн зохих зардлаас олгохыг Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаад зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.НАРАНПҮРЭВ

050001